

“Зоос банк” ХК-ийн нэмж гаргах
хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.2, 9.8, 34.1.7 дахь заалт, Компанийн тухай хуулийн 43.3 дахь заалт, “Зоос банк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2007 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хурлын 02 тоот тогтоол, ТУЗ-ийн 2007 оны 10 дугаар сарын 23-ны 60 тоот тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Зоос банк” ХК-ийн хаалттай хэлбэрээр нэмж гаргаж буй нэг бүр нь 1000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2 000 000 /хоёр сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “МХБ” ХК /Р.Содхүү/, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2.Энэхүү тогтоолын 1-д заасан нэмж гаргаж байгаа хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлсэн Монгол улсын иргэн Сүхбаатарын Болорчимэг /УБ 0296943 тоот иргэний үнэмлэх, УХ74121864 тоот регистрийн дугаар бүхий/-ийн худалдан авсан гэх 26 ширхэг хувьцааг түүний 6-454682 тоот дансанд шилжүүлэн бүртгэж өмчлөх эрхийг нь баталгаажуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тогтоолын 2-т зааснаас бусад 1999974 ширхэг хувьцааг “Зоос банк” ХК-ийн ТУЗ-ийн 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 65 тоот тогтоолын хавсралтаар баталсан Д.Батбаяраас бусад хөрөнгө оруулагч нарт гэрээний үндсэн дээр худалдахыг зөвшөөрч, худалдан авсан этгээд нь үнэт цаасны 2 дахь зах зээл дээр нэгээс доошгүй жилийн хугацаанд бусдад хувьцаагаа худалдахгүй байх шаардлагыг уг гэрээнд тусгахыг “Зоос банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын 3-т заасан хувьцааг тогтоол батлагдсанаас хойш 1 жилийн хугацаанд багтаан хөрөнгө оруулагчдад хаалттай хэлбэрээр худалдаагүй тохиолдолд холбогдох хувьцааны бүртгэх зөвшөөрлийг хүчингүй болгож ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгаж, “Зоос банк” ХК /Ш.Чуданжий/-д анхааруулсугай.

5.Энэхүү тогтоолын 3-т заасны дагуу хөрөнгө оруулагчтай хувьцаа худалдах, худалдан авах талаар байгуулсан гэрээ болон холбогдох төлбөрийг төлж дууссан талаар баримтыг Хороонд ирүүлж, тус Хорооноос олгох зөвшөөрлийг үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэхийг “МХБ” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/ нарт үүрэг болгосугай.

6.Хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээний талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлж үнэт цаасны арилжааны гүйлгээний тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Зоос банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Батбаяр/-д үүрэг болгосугай.

7.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ